



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1.Төрийн албан хаагчдыг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн талаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг хэлэлцээд дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1/Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг чангатган хариуцлага тооцож, Төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас нь чөлөөлсний улмаас төсөвт учирсан хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах;


2/Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг зөрчин сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон зарим яамдын Төрийн нарийн бичгийн дарга, газар, агентлагийн дарга нарыг томилсон хууль бус шийдвэрүүдийг хүчингүй болгож, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт нийцүүлэх;

3/Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын хүрээнд төрийн албан хаагчдыг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн, хууль зөрчин томилсон шийдвэрүүдийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авч ажиллах;

4/Төрийн албан хаагчийг улс төрийн албан тушаалтан томилж, чөлөөлөхөөр заасан хуулиудад төрийн алба улс төрөөс ангид байх зарчимд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

2.Тогтоолын биелэлтийг 2015 оны 7 дугаар сарын 10-ны дотор тус Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



О.БААСАНХҮҮ